

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн тамгын газар 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨВА-2023/213/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Арвайхээр хот 2023 он	Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn Аудитор: Э.Энхбаяр Утас: 70323833 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.МӨНХБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн тамгын газар 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн тамгын газар 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Шүүхийн газар нь үндсэн үйл ажиллагааны дансандаа Улсын төсвөөс 1272.7 сая төгрөгийн урсгал санхүүжилт авч 1175.7 сая төгрөгийг цалин, нийгмийн даатгал, бараа, ажил үйлчилгээний зардалд зарцуулж 97.0 сая төгрөгийг улсын төсвийн байгууллагын татан төвлөрүүлэлт дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансандаа аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох насанд хүрээгүй хүүхдээс тайлбар, мэдүүлэг авах тусгай өрөөг тохижуулах зардалд 10.1 сая төгрөгийн санхүүжилт авч бүрэн зарцуулжээ.

Санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээллийг шалгахад Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шилжүүлэн авсан хөрөнгүүдийг орлогод авч, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 41 ширхэг 50.4 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг холбогдох байгууллагын шийдвэрийг үндэслэн акталж данснаас хассан байна. Мөн 158 ширхэг 132.6 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагын шийдвэрээр үнэ шинэчлэн тогтоосон болон ашиглах хугацааг сунгаж үндсэн хөрөнгийн тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант үеийн санхүүгийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байна. Бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

115034287

D:\New Volume\2023 on\Bichig khereg\A4

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О. БАТЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,963,648.00	14,562,278.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,900,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	2,900,000.00
3121	Төгрөг	-	2,900,000.00
31211	Төрийн сангийн харилцах	-	2,900,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	17,963,648.00	11,662,278.00
354	Хангамжийн материал	17,963,648.00	11,662,278.00
35410	Бичиг хэргийн материал	5,536,710.00	5,313,560.00
35440	Түлш, шатах тослох материал	1,318,500.00	500.00
35470	Бусад хангамжийн материал	11,108,438.00	6,348,218.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	776,313,015.10	747,586,785.22
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	776,313,015.10	747,586,785.22
392	Биет хөрөнгө	755,117,848.43	726,733,285.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	563,309,954.47	563,309,954.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	(50,674,122.00)	(67,565,496.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	208,065,500.00	154,865,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(92,072,243.10)	(48,211,159.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	240,284,678.24	180,572,454.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	(145,159,249.30)	(94,951,608.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	105,461,561.00	98,928,947.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(75,451,074.10)	(62,057,553.42)
39209	Зам, гүүрийн байгууламж	3,410,968.00	3,410,968.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(3,387,384.78)	(3,399,181.42)
39217	Ном	1,329,260.00	1,830,460.00
393	Биет бус хөрөнгө	21,195,166.67	20,853,500.09
39301	Програм хангамж	1,495,000.00	1,495,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(715,833.33)	(1,057,499.91)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,416,000.00	20,416,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	794,276,663.10	762,149,063.22
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	794,276,663.10	762,149,063.22
51	Засгийн газрын хувь оролцоо	794,276,663.10	762,149,063.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	631,862,535.00	631,862,535.00
51101	Өмч:- төрийн	631,862,535.00	631,862,535.00
512	Хуримтлагдсан үр дүн	(81,293,126.96)	(113,420,726.84)
51210	Өмнөх үеийн үр дүн	(147,854,058.79)	(81,293,126.96)
51220	Тайлант үеийн үр дүн	66,560,931.83	(32,127,599.88)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	243,707,255.06	243,707,255.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	794,276,663.10	762,149,063.22

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,177,740,847.00	1,341,202,439.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	127,120,347.00	58,445,439.60
120	Нийтлэг татварын бус орлого	127,120,347.00	58,445,439.60
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	127,120,347.00	13,539,230.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	127,120,347.00	13,539,230.00
120009	Бусад орлого	-	44,906,209.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,050,620,500.00	1,282,757,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,700,000.00	10,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,700,000.00	10,000,000.00
1330	Төсвийн захирагчдаас	1,039,920,500.00	1,272,757,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,039,920,500.00	1,272,757,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,111,179,915.17	1,373,330,039.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,111,179,915.17	1,373,330,039.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,077,302,949.11	1,272,226,218.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	732,493,873.98	906,678,961.00
210101	Үндсэн цалин	635,650,490.61	647,472,175.00
210102	Нэмэгдэл	45,739,905.00	200,221,613.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,962,998.37	23,814,000.00
210104	Урамшуулал	26,140,480.00	35,171,173.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,966,443.34	116,164,436.10
210201	Тэтгэврийн даатгал	69,003,323.70	79,440,647.03
210202	Тэтгэмжийн даатгал	7,695,529.91	9,339,873.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,938,023.76	7,334,999.98
210204	Ажилгүйдлийн даатгал	1,484,506.15	1,822,628.86
210205	Эрүүл мэндийн даатгал	14,845,059.82	18,226,286.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол	35,855,200.00	42,489,318.00
210301	Гэрэл, цахилгаан	5,641,508.00	7,456,678.00
210302	Түлш, халаалт	29,234,162.00	33,724,960.00
210303	Цэвэр, бохир ус	979,530.00	1,307,680.00
2104	Хангамж, бараа материалын зардал	68,401,446.00	67,978,432.00
210401	Бичиг хэрэг	17,332,540.00	30,294,500.00
210402	Тээвэр, шатахуун	25,424,500.00	20,097,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,429,525.00	10,984,523.00
210404	Ном, хэвлэл	9,500,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,086,000.00	1,086,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,628,881.00	5,516,409.00
2105	Нормативт зардал	800,000.00	316,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	316,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,130,600.00	21,438,438.00
210604	Урсгал засвар	44,130,600.00	21,438,438.00
2107	Томилолт, зочны зардал	6,360,200.00	12,609,200.00
210702	Дотоод албан томилолт	6,360,200.00	12,609,200.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,531,210.62	12,175,054.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,026,790.62	9,275,532.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,148,900.00	2,535,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	144,820.00	238,922.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	397,000.00	-
210807	Газрын төлбөр	69,700.00	48,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	700,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,763,975.17	92,376,379.48
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,763,975.17	92,376,379.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,876,966.06	101,103,820.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	4,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	4,100,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,876,966.06	97,003,820.90
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,876,966.06	97,003,820.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	66,560,931.83	(32,127,599.88)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	66,560,931.83	(32,127,599.88)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,050,620,500.00	1,289,919,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	7,162,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	7,162,000.00
120009	Бусад орлого	-	7,162,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,050,620,500.00	1,282,757,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,700,000.00	10,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,700,000.00	10,000,000.00
1330	Төсвийн захирагчдаас	1,039,920,500.00	1,272,757,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,039,920,500.00	1,272,757,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,026,752,700.00	1,279,019,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,026,752,700.00	1,279,019,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	992,875,733.94	1,177,915,179.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	732,493,873.98	913,678,961.00
210101	Үндсэн цалин	635,650,490.61	654,544,703.00
210102	Нэмэгдэл	45,739,905.00	200,184,946.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,962,998.37	23,778,139.00
210104	Урамшуулал	26,140,480.00	35,171,173.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,966,443.34	116,164,436.10
210201	Тэтгэврийн даатгал	69,003,323.70	79,440,647.03
210202	Тэтгэмжийн даатгал	7,695,529.91	9,339,873.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,938,023.76	7,334,999.98
210204	Ажилгүйдлийн даатгал	1,484,506.15	1,822,628.86
210205	Эрүүл мэндийн даатгал	14,845,059.82	18,226,286.50

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,855,200.00	42,489,318.00
210301	Гэрэл, цахилгаан	5,641,508.00	7,456,678.00
210302	Түлш, халаалт	29,234,162.00	33,724,960.00
210303	Цэвэр, бохир ус	979,530.00	1,307,680.00
2104	Хангамж, бараа материалын зардал	64,331,206.00	64,966,782.00
210401	Бичиг хэрэг	16,958,800.00	28,470,850.00
210402	Тээвэр, шатахуун	16,728,000.00	18,779,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,429,525.00	10,984,523.00
210404	Ном, хэвлэл	14,500,000.00	130,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,086,000.00	1,086,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,628,881.00	5,516,409.00
2105	Нормативт зардал	800,000.00	316,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	316,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,537,600.00	15,515,428.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	118,000.00	-
210604	Урсгал засвар	48,419,600.00	15,515,428.00
2107	Томилолт, зочны зардал	6,360,200.00	12,609,200.00
210702	Дотоод албан томилолт	6,360,200.00	12,609,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	5,531,210.62	12,175,054.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,026,790.62	9,275,532.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,148,900.00	2,535,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	144,820.00	238,922.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	397,000.00	-
210807	Газрын төлбөр	69,700.00	48,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	700,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,876,966.06	101,103,820.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	4,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	4,100,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,876,966.06	97,003,820.90
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,876,966.06	97,003,820.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	23,867,800.00	10,900,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	23,867,800.00	8,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,867,800.00	8,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	23,867,800.00	8,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	23,867,800.00	8,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(23,867,800.00)	(8,000,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	2,900,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,900,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	631,862,535.00	243,707,255.06	(147,854,058.79)	727,715,731.27
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	631,862,535.00	243,707,255.06	(147,854,058.79)	727,715,731.27
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	66,560,931.83	66,560,931.83
8	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	631,862,535.00	243,707,255.06	(81,293,126.96)	794,276,663.10
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	631,862,535.00	243,707,255.06	(81,293,126.96)	794,276,663.10
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
16	Тайлант үеийн үр дүн	-	-	(32,127,599.88)	(32,127,599.88)
17	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	631,862,535.00	243,707,255.06	(113,420,726.84)	762,149,063.22

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,274,757,000.00	1,175,753,179.10	99,003,820.90	92.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,274,757,000.00	1,175,753,179.10	99,003,820.90	92.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,272,757,000.00	1,175,753,179.10	97,003,820.90	92.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	979,644,300.00	913,678,961.00	65,965,339.00	93.3
210101	Үндсэн цалин	652,987,100.00	654,544,703.00	(1,557,603.00)	100.2
210102	Нэмэгдэл	277,427,700.00	200,184,946.00	77,242,754.00	72.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,272,200.00	23,778,139.00	1,494,061.00	94.1
210104	Урамшуулал	23,957,300.00	35,171,173.00	(11,213,873.00)	146.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,455,600.00	116,164,436.10	6,291,163.90	94.9
210201	Тэтгэврийн даатгал	83,269,800.00	79,440,647.03	3,829,152.97	95.4
210202	Тэтгэмжийн даатгал	9,796,400.00	9,339,873.73	456,526.27	95.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,837,200.00	7,334,999.98	502,200.02	93.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,959,300.00	1,822,628.86	136,671.14	93.0
210205	Эрүүл мэндийн даатгал	19,592,900.00	18,226,286.50	1,366,613.50	93.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,179,400.00	42,489,318.00	2,690,082.00	94.0
210301	Гэрэл, цахилгаан	8,003,000.00	7,456,678.00	546,322.00	93.2
210302	Түлш, халаалт	33,726,400.00	33,724,960.00	1,440.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	3,450,000.00	1,307,680.00	2,142,320.00	37.9
2104	Хангамж, бараа материалын зардал	65,875,300.00	64,804,782.00	1,070,518.00	98.4
210401	Бичиг хэрэг	28,000,000.00	28,308,850.00	(308,850.00)	101.1
210402	Тээвэр, шатахуун	17,946,300.00	18,779,000.00	(832,700.00)	104.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,193,000.00	10,984,523.00	1,208,477.00	90.1
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	130,000.00	870,000.00	13.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,086,000.00	1,086,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,650,000.00	5,516,409.00	133,591.00	97.6
2105	Нормативт зардал	800,000.00	316,000.00	484,000.00	39.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	316,000.00	484,000.00	39.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,000,000.00	13,515,428.00	5,484,572.00	71.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	-	5,000,000.00	-
210604	Урсгал засвар	14,000,000.00	13,515,428.00	484,572.00	96.5
2107	Томилот, зочны зардал	12,635,000.00	12,609,200.00	25,800.00	99.8
210702	Дотоод албан томилот	12,635,000.00	12,609,200.00	25,800.00	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,167,400.00	12,175,054.00	7,992,346.00	60.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,250,000.00	9,275,532.00	7,974,468.00	53.8
210803	Даатгалын үйлчилгээ	2,553,400.00	2,535,600.00	17,800.00	99.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	239,000.00	238,922.00	78.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	48,000.00	48,000.00	-	100.0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,000,000.00	-	7,000,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,000,000.00	-	7,000,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	-	2,000,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	-	2,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	-	2,000,000.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,274,757,000.00	1,274,757,000.00	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	5.00	5.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	5.00	5.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	39.00	38.00	1.00	97.4
620001	Удирдах ажилтан	5.00	5.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	30.00	29.00	1.00	96.7
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	17.00	16.00	1.00	94.1
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	12.00	12.00	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,162,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,162,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,162,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,162,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,162,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	162,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өвөрхангай аймаг дахь Шүүхийн Тамгын газар нь шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хөндлөнгөөс оролцохгүйгээр Шүүхийн захиргааны тухай хуулийн 86 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулдаг Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Шүүхийн Тамгын газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн захиргааны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Шилэн дансны тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн Тамгын газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасны дагуу Нягтлан бодох бүртгэлийн хууль болон СТОУС, УСНББОУС-ын шаардлагыг үндэслэн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдүүлэхээр 2020 онд баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Шүүхийн тамгын газар 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Энэхүү бодлогын баримт бичиг нь анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайлан бэлтгэж толилуулах, тайлан бэлтгэж гаргах ажиллагаатай холбоотой МУ-ын хууль тогтоомж, журам болон УСНББОУС, МУ-ын Сангийн сайдын тушаалаар баталсан журам, заавар, аргачлалд нийцсэн, тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа явуулах журам, дүрэмд тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шүүхийн тамгын газар 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	2900.0	2900.0
Авлага	-	-	-
Бараа материал	17963.6	11662.2	-6301.4
Үндсэн хөрөнгө	776313.0	747586.7	-28726.2
Нийт хөрөнгө	794276.6	762149.0	-32127.6
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	794276.6	762149.0	-32127.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	794276.6	762149.0	-32127.6

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 32127.6 сая төгрөгөөр буюу 4 хувиар буурсан байна.

Дээрх хүснэгтээс харахад, нийт хөрөнгө өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн тайлант хугацааны элэгдэл болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 287 дугаар тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан ч цаашид ашиглах боломжтой хөрөнгүүдийн ашиглах хугацаа болон үнэ шинэчлэн тогтоосон 158 ширхэг 132.6 сая төгрөгийн хөрөнгө, анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгүүдийг акталж данснаас хассан 41 ширхэг 50.4 сая төгрөг, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шилжүүлэн авсан 10.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансны хөрөнгөөр худалдан авсан 8.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө зэрэг үндсэн хөрөнгийн хөдөлгөөнд өөрчлөлт орсонтой холбоотой буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1615.5 сая, нийт зарлагыг 1615.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 340.8 сая төгрөгөөр бууруулж 1274.7 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь хэмнэлтийн зарчимд нийцүүлэн ажиллагсадтай холбоотой зардлыг 157.7 сая төгрөгөөр эд хогшил, урсгал засварын зардлыг 95.5 сая төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 3.4 сая төгрөгөөр томилолтын зардлыг 3.8 сая төгрөгөөр тус тус бууруулан баталснаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 132.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1274.7 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2.0 сая төгрөгөөр дутуу буюу 1272.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, 97.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1272.7 сая төгрөг буюу 92.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 72.2 сая, багаж техник хэрэгслийн зардлыг 5.0 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 7.0 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 2.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр зардлыг 7.9 сая төгрөг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	70701-Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах	1274757.0	1175752.2	99004.8	92.2
	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1263257.0	1173335.9	89921.1	92.8
	80224-Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	4500.0	590.3	3909.7	13.1
	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2000.0	-	2000.0	0.0
	82321-Шинжээч орчуулагч, хэлмэрчийн зардал	5000.0	1826.0	3174.0	36.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох насанд хүрээгүй хүүхдээс тайлбар, мэдүүлэг авах тусгай өрөөг тохижуулах зардалд 10000.0 мянган төгрөгийн санхүүжилтыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс, шинжээч орчуулагч хэлмэрчийн бичиг хэргийн зардалд 162.0 мянган төгрөгийн санхүүжилтийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс авч бүрэн зарцуулжээ. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Шүүхийн Тамгын газар 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газар Аудитор Э.Энхбаяр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг, аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн тамгын газар 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн Т/27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1373.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 13.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага багаж техник хэрэгслийн зардлыг зарцуулах шийдвэр гаргаагүй, бараа үйлчилгээний бусад зардал болон нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал гаргаагүй зэрэг арга хэмжээ авч ажилласан байна. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д зааснаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг хамаараагүй.

Энэ хуулийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны зардлаас нийт 97.0 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож, төсөвт буцаан төвлөрүүлжээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шүүхийн тамгын газар нь Шилэн дансны хууль, журмын дагуу батлагдсан маягтаар мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тухайн байгууллагад тайлант онд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн	-	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нэмэлт санхүүжилтийн дансанд орсон орлого, зарлагыг санхүүгийн тайланд дутуу бүртгэснээс тайлан буруу илэрхийлэгдэж тайлагнасан байна. Иймд дараагийн аудитаар нэмэлт санхүүжилтийн дансанд орсон орлого, зарлагыг орхигдуулах магадлалтай тул анхаарах.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн								
Нийт дүн								

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

